

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар хот

Г Хорооны 2006 оны 25 дугаар тогтоолоор Г
батлагдсан журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 23.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.2, Хорооны 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 2006 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-д дараах агуулгатай тав дахь зүйлийг нэмсүгэй:

1/ “ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ

5.1. Хороо нь үнэт цаасны зах зээл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн мэдээллийг №А1 маягтын дагуу бүртгэнэ.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд нь дор дурьдсан нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор Хороонд тэр тухай бичгээр мэдэгдэнэ:

5.2.1. Мэргэжлийн байгууллага Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг эрхлэхээ зогсоох тухай шийдвэр гаргасан;

5.2.2. Энэ журмын 5.1-д заасан №А1 маягт дахь мэдээлэлд өөрчлөлт орсон;

5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн бүртгэл дэх мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хадгалах бөгөөд түүний хадгалалт, хамгаалалтыг Хорооны бүртгэл хариуцсан мэргэжилтэн хариуцна.

5.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн бүртгэл дэх мэдээллийг хувийн сонирхлоор, хууль бусаар ашиглахыг хориглоно.

Зургаа. Мэдээллийг олон нийтэд хүргэх

6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдээс ирүүлсэн энэхүү журмын 5.1-д заасан мэдээллийг дараах байдлаар дор дурьдсан этгээд олон нийтэд мэдээлнэ:

6.1.1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага /МХБ/ ажлын 3 хоногийн дотор өөрийн веб хуудас болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж;

6.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь мэдээллийг өөрийн веб хуудсаар дамжуулан ажлын 5 хоногийн дотор;

6.2. Хэрэв хөрөнгө оруулагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зохицуулалттай этгээдийн бүртгэл дэх энэхүү журмын 5.1-д заасан мэдээлэлтэй ажлын цагаар үнэ төлбөргүй танилцаж болно.

2/ Хорооны 2006 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ын 2.1 дэх хэсгийн хүснэгтийн 3 дугаар мөрний “ҮНЭТ ЦААС” гэсэн хэсгийн “Үнэт цаасны хадгаламжийн” гэсний дор “Кастодианы 321/” гэсэн 4 дэх мөрийг, “Үнэт цаас бүртгэгчийн 322/” гэсэн 5 дахь мөрийг, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “А1” маягтын 1 дэх хэсгийн “Утас, емейл, гэрийн хаяг” гэсэн 14 дэх мөрний дор “Аудиторын овог нэр” гэсэн 15 дахь мөр, “Утас, емейл, гэрийн хаяг” гэсэн 16 дахь мөр, “Дотоод хяналтын ажилтны овог нэр” гэсэн 17 дахь мөр, “Утас, емейл, гэрийн хаяг” гэсэн 18 дахь мөр, “Үнэт цаасны зах зээлд ажиллах эрх бүхий ажилтны нэр¹” гэсэн 19 дэх мөр, “Утас, емейл, гэрийн хаяг” гэсэн 20 дахь мөрийг, мөн маягтын 1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэсний дараа “эрх” гэж, мөн маягтын ишлэл хэсэгт “¹Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд хамаарна” гэж тус тус нэмсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ын 2.1 дэх хэсгийн хүснэгтийн 5 дахь мөрний “Үйл ажиллагааны эрх” гэсэн хэсгийн 3 дахь мөрний “Аудитын даатгагчийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрх” гэснийг “Даатгалын байгууллагад аудит хийх эрх” гэж, 3.1.3 дэх заалтын “дараах үсэг, тооноос бүрдэнэ. Эхний 2 тэмдэгт нь уг үнэт цаас гаргагчийн ерөнхий захиргаа байршиж байгаа аймаг, хотын нэрийг товчилсон 2 үсэг, дараагийн 8 тоо нь үнэт цаас бүртгүүлэхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэр гарсан огноог илэрхийлнэ” гэснийг “Үнэт цаасанд дугаарлалт хийх журам”-ын дагуу эрх бүхий байгууллагаас олгосон дугаар байна” гэж, 4.4 дэх заалтын “Бодлого зохицуулалтын газар” гэснийг “Тамгын газар” гэж, 4.7 дахь заалтын “Мониторинг судалгааны газар” гэснийг “Мэдээлэл технологийн

хэлтэс” гэж, мөн заалтын “үүднээс” гэснийг “бөгөөд” гэж, “үүрэг” гэснийг “үүргийг Тамгын газар” гэж тус тус өөрчилсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 7 сарын 07-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ын 1.2.3.5 дахь заалтыг, 2.1 дэх хэсгийн хүснэгтийн 1 дүгээр мөрний “Банк бус санхүүгийн байгууллага” гэсэн хэсгийн 3 дахь мөрний “Валютын үйлчилгээний цэгийн зөвшөөрөл” гэснийг тус тус хассугай.

4. Журамд өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Маягт № А1

**Санхүүгийн зохицуулах хорооноос зэрэглэл тогтоох этгээдэд
эрх олгох үйл ажиллагааны бүртгэл**

Бүртгэлийн дугаар

№	Бүртгэлийн асуулга		Үзүүлэлт	
1	Эрх хүсэгч аж ахуйн нэгж	Байгууллагын нэр		
		Оршин байх газар, хаяг		
		Өмчийн хэлбэр		
		Үүсгэн байгуулсан хэлбэр		
		Хувь нийлүүлэгчийн тоо, нэрс		
		Эрхэлж буй үйл ажиллагаа	Үндсэн	
		Дүрмийн сангийн хэмжээ /төг/		
		Гүйцэтгэх захирлын овог нэр		
		Утас, емэйл, гэрийн хаяг		
		ТУЗ, Тэргүүлэгчдийн овог, нэр		
		Ерөнхий нягтлан бодогчийн овог нэр		
		Утас, емэйл, гэрийн хаяг		
		Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн	Дугаар	
			Регистрийн дугаар	
Татвар төлөгчийн дугаар				
2	Хорооноос олгосон эрхийн	Эрхлэх үйл ажиллагааны	Төрөл	
			Ангилал	
			Хэлбэр	
	Олгосон шийдвэрийн		Дугаар	
			Огноо	
			Хүчинтэй байх хугацаа	
	Индекс/ бүртгэлийн дугаар/			
Бүртгэсэн огноо				

Бүртгэсэн: Хариуцсан газрын мэргэжилтэн:

Хянасан: Хариуцсан газрын дарга:

Нэгдсэн бүртгэл хариуцсан мэргэжилтэн:

Хянаж зөвшөөрсөн: Тамгын газрын дарга

Баталсан: Албаны дарга

/Тэмдэг/

Бүртгэлд орсон өөрчлөлтийн тухай тэмдэглэл

№	Бүртгэлд орсон өөрчлөлт	Өөрчлөлтийн оруулсан үндэслэл, шийдвэр, огноо	Тэмдэглэл хийсэн хүний гарын үсэг	Баталгаажуулалт /тамга/

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн бүртгэл

Бүртгэлийн дугаар

№	Бүртгэлийн асуулга	Үзүүлэлт	
1	Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж	Байгууллагын нэр	
		Оршин байх газар, хаяг	
		Өмчийн хэлбэр	
		Үүсгэж байгуулсан хэлбэр	
		Хувь нийлүүлэгчийн тоо, нэрс	
		Эрхэлж буй үйл ажиллагаа	Үндсэн
			Нэмэгдэл
		Дүрмийн сангийн хэмжээ /төг/	
		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ/төг/	
		Гүйцэтгэх захирлын овог нэр	
		Утас, email, гэрийн хаяг	
		ТУЗ-ийн дарга, гишүүдийн овог нэр	
		Утас, email, гэрийн хаяг	
		Ерөнхий нягтлан бодогчийн овог нэр	
		Утас, email, гэрийн хаяг	
		Аудиторын овог нэр	
		Утас, email, гэрийн хаяг	
		Дотоод хяналтын ажилтны овог нэр	
		Утас, email, гэрийн хаяг	
		Үнэт цаасны зах зээлд ажиллах эрх бүхий ажилтаны нэр¹	
Утас, email, гэрийн хаяг			
Аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн	Дугаар		
	Регистрийн дугаар		
	Татвар төлөгчийн дугаар		
2	Тусгай зөвшөөрөл хүсэгч Иргэн	Иргэний овог нэр	
		Оршин байх хаяг, утас	
		Эрхэлж буй үйл ажиллагаа	
		Иргэний үнэмлэхний	Дугаар
Регистрийн дугаар			
Татвар төлөгчийн дугаар			
3	Хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн	Эрхлэх үйл ажиллагааны	Төрөл
			Ангилал
			Хэлбэр
		Олгосон шийдвэрийн	Дугаар
			Огноо
			Хүчинтэй байх хугацаа
Индекс/ бүртгэлийн дугаар/			
Бүртгэсэн огноо			

- Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн тухайд Үнэт цаасны зах зээлд ажиллах эрх бүхий ажилтаны нэр, хаягийг бүртгэнэ.

Бүртгэсэн: Хариуцсан газрын мэргэжилтэн:

Хянасан: Хариуцсан газрын дарга:

Бүртгэл хариуцсан мэргэжилтэн:

Хянаж зөвшөөрсөн: Тамгын газрын дарга

Баталсан: Албаны дарга

/Тэмдэг/

Бүртгэлд орсон өөрчлөлтийн тухай тэмдэглэл

№	Бүртгэлд орсон өөрчлөлт	Өөрчлөлтийн оруулсан үндэслэл, шийдвэр, огноо	Тэмдэглэл хийсэн хүний гарын үсэг	Баталгаажуулалт /тамга/

Салбарын тэмдэглэл

№	Салбарын нэр	Салбарын хаяг	Байгуулагдсан он сар, шийдвэр, огноо	Тэмдэглэл хийсэн хүний гарын үсэг